



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2023 оны 10 сарын 06 өдөр

Дугаар A/76

Улаанбаатар хот

Төрийн өмчийн төлөөлөгчийг
томилж, удирдамж батлах тухай


Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг, 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Монголын цахилгаан холбоо” хувьцаат компанийн 2022 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд төрийн өмчийн төлөөлөгчөөр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төлөвлөлт, хөрөнгө оруулалтын албаны дарга Цэрэннадмидын Шинэхүүг томилсугай.

2. “Монголын цахилгаан холбоо” хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцэх асуудалд өгөх саналын удирдамжийг хавсралтаар баталсугай.

3. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд удирдамжийг баримтлан оролцох, хуралд оролцсон тайланг танилцуулахыг төрийн өмчийн төлөөлөгч Цэрэннадмидын Шинэхүүд даалгасугай.

ДАРГА



Б.ЦЭНГЭЛ

132013685

ТӨБЗГ тушаал-/2023

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын даргын 2023 оны 10 сарын 06-ны
өдрийн 476 дугаартай тушаалын хавсралт

**“МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРАЛД ТӨРИЙН ӨМЧИЙГ ТӨЛӨӨЛӨН
ОРОЛЦОХ ТӨЛӨӨЛӨГЧИЙН БАРИМТЛАХ УДИРДАМЖ**

Төрийн өмчийн төлөөлөгч нь компанийн Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн ээлжит бус хурлаар хэлэлцэх асуудал шийдвэр гаргахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйл, “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам” болон энэхүү удирдамжийг баримтална:

1. Монгол Улсын Их Хурлын 2022 оны 16 дугаар тогтоол, Засгийн газрын 2022 оны 244 дүгээр тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 336 дугаар тогтоол, бусад холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын дагуу Компанийн хувьцааг нэмж гаргах, олон нийтэд санал болгохыг дэмжиж оролцох.
 - Холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, тогтоол шийдвэрийн дагуу “Монголын цахилгаан холбоо” хувьцаат компанийн төрийн мэдлийн хувьцаа 66 хувь байх хэмжээнд Компанийн зарласан хувьцааны тоог нэмэгдүүлэх;
 - Холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, тогтоол шийдвэрийн дагуу Компанийн одоогийн гаргасан 25,870,276 (хорин таван сая найман зуун далан мянга хоёр зуун далан зургаа) ширхэг энгийн хувьцаа дээр компанийн төрийн мэдлийн хувьцаа 66 хувь байх хэмжээнд хувьцаа нэмж гаргах, нэмж гаргасан хувьцааг олон нийтэд санал болгох;
 - Холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, тогтоол шийдвэрийн дагуу “Монголын цахилгаан холбоо” хувьцаат компанийн төрийн мэдлийн хувьцаа 66 хувь байх хэмжээнд олон нийтэд нээлттэй санал болгох хувьцааны тоо ширхгийг тогтоох;
 - Нэмж гаргах хувьцааны олон нийтэд санал болгох зах зээлийн үнийг хараат бус бизнесийн үнэлгээний тайланд үндэслэн тогтоох бүрэн эрхийг Төлөөлөн удирдах зөвлөлд олгох;
 - Компанийн одоогийн хувьцаа эзэмшигчдийн нэмж гаргах хувьцаанаас тэргүүн ээлжид худалдан авах давуу эрхийг хэрэгжүүлэх эсэхийг эрх бүхий байгууллагуудаас гаргасан тогтоол шийдвэрийн хэрэгжилттэй холбогдуулан шийдвэрлэх;
 - Хувьцааны захиалгын хэмжээ давж биелсэн тохиолдолд нийтэд санал болгон гаргасан хувьцааны хэдэн хувьтай тэнцэх хэмжээний хувьцааг нэмж гаргахыг холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, тогтоол шийдвэрийн хүрээнд тогтоох;
 - Компанийн одоогийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болон стратегийн хөрөнгө оруулагч нь хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжаа

- нээгдсэнээс хойш 6 сарын хугацаанд хувьцаагаа арилжаалахгүй байх буюу тусгаарлуулах үүрэг хүлээх талаар чиглэл өгөх;
- Олон нийтэд хувьцаа нэмж гаргахтай холбоотой шийдвэрийн биелэлтийг хангаж ажиллах, Санхүүгийн зохицуулах хороо болон “Монголын хөрөнгийн бирж” ХК-д хувьцаагаа бүртгүүлэхэд шаардлагатай бүх талын арга хэмжээг авч ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд даалгах;
 - Хувьцаа нэмж гарган, олон нийтэд санал болгохтой холбоотой бусад асуудлыг тухай бүр хэлэлцэн шийдвэрлэх бүрэн эрхийг Төлөөлөн удирдах зөвлөлд олгох;
 - Нэмж гаргасан хувьцааг зах зээлд нээлттэй арилжаалахыг Санхүүгийн зохицуулах хороо болон “Монголын хөрөнгийн бирж” ХК-иас зөвшөөрсөн хүрээнд хувьцааны анхдагч зах зээлийн арилжаа амжилттай болсны дараа зохион байгуулах, Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх Компанийн “Дүрмийн төсөл”-тэй танилцаж үүрэг чиглэл өгөх.
2. Компанийн одоогийн хувьцаа эзэмшигчдийн нэмж гаргах хувьцаанаас тэргүүн ээлжид худалдан авах давуу эрхийг хэрэгжүүлэх эсэхийг эрх бүхий байгууллагуудаас гаргасан тогтоол шийдвэрийн хэрэгжилттэй уялдуулан хэрхэн шийдвэрлэсэнтэй холбогдуулж, 2023 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын 02 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцох эсэхийг шийдвэрлэх;
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг холбогдох хууль тогтоомжийн дагуу сонгох.